

**Резонанс $\text{He}(1^1\text{S})(e, 2e)\text{He}'(1s)$ урвал дахь
мөргөлдөөний дараах үйлчлэлцлийн нөлөө**

О.Лхагва, Л.Хэнмэдэх, Ж. Мэдсон

Ер давлай усвар үл ханах
Их ухаантан эрдмээр үл ханах
(Субашидээс)

Материйн бүтцийн голомт руу нэвтрэх их тэмцэлдээ хүмүүн бөөмсийн харилцан үйлчлэлцлийн язгур шинжийг илрүүлэхээр зорьж байна. Үүний зэрэгцээ хоёроос дээш тооны бөөмс аль ч хүчиний үйлчлэлээр огторгуйхугацааны “тэнгэр” доор хэрхэн хувиран бужигнах, яваандаа ямар төрх төрөл олохыг зурж илэрхийлэх нь голгооч ач тустай. Танин мэдэхүйн физик эрдэм дэх тулгын нэгэн чулуу нь энэ мен.

Энэхүү ажилд бид хөнгөн (H , He) атом элэктронтой мөргөлдөх үед асах шууд ба (ергөө) резонанс урвалын дараах гурван цэнэгт бөөмийн харилцан үйлчлэл автоионжих төлвийн шинжүүрт хэрхэн нөлөөлэхийг судлах нэгэн шинэ сэдэл дэвшүүлэв. Нэлээд эртхэн Сенашенко нар [1] хурдан протоноор гелийн атомд асах ийн урвалыг судалсан байв. Урвалын отголыг тооцоолсон тэдний параметрт (Шоре-Балашов) арга нь эцсийн харилцан үйлчлэлтэй (ЭХҮ) тохиолдолд резонансыг илэрхийлэхэд тохиорхгүйг илрүүлэв. Харин тэд нар резонанс тувагийн томъёонд ЭХҮ-д дүйсэн үргжигдэхүүн (К) ялан гаргасан нь цаашид резонанс ($e, 2e$) урвалыг илэрхийлэх өөр арга санаа сэдэхэд чухал сэжүүр цүхүүлгасан байв.

Кроувэ, Балашов нар[2] саяхан ($e, 2e$) урвалаар үүсэх автоионжих төлвүүдийг бүрэн туршлагаар илэрхийлэх санаа дэвшүүлж, түндээ Борны нэгдүгээр дэхэлтэд ЭХҮ-г тооцолгүйгээр онолын эгэл арга дүйцүүлэхийг оролджээ. 1^1S автоионжих төлвийн хувьд тэдний шинээр санначилсан ICI параметрын туршлагын утга нь цойлсон электроны өнцгөөс тод хамааралтай байхад онолоор нь тогтмол утгатай байв. Өмнөх ажилд[3] Кроувэ, Балашов нарын[2] санааг ЭХҮ-г тооцон К үргжигдэхүүн оруулж урвалыг илэрхийлэх математик аппарат дэюүлүүсэн юм. Ургэлжлэл тооцоонд нь ЭХҮ-г гурван төвт кулоны функцизэр[4] ор суулган илэрхийлэв. Бидний тооцоо өмнө дурьдсан туршлагын ICI параметрийн төрхийг сайн тодруулж байна. Харин түүний тоон хэмжээ нь туршлагын нарийвчлал мэдрэмж болон тооцоонд оруулсан “цаагдал” хоёроос хүчтэй хамаарч байна. Эл ажлын дүнг олон улсын хуралд сонсгож, хэвлэлд илгээхээр зэхжэй байна.

Ишлэл

1. В. С. Сенашенко и др. ЖЭТФ, 80, (1989), 2456
2. V. V. Balshov, S. E. Martin and A. Crowe, J. Phys.B. 29 (1996), L337
3. Л.Хэнмэдэх, О.Лхагва, Ж.Мэдсон, МУИС, ЭШБ, хэвлэлд
4. M. Brauner, J. Briggs and H. Klar, J. Phys.B. 22 (1989), 2265.